



## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 04 сарын 26 өдөр

Дугаар 154

Улаанбаатар хот

### Зөвшөөрлийн зөвлөлийн гишүүдийг томилох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 23.1.6, 30 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 9.1-д заасныг тус тус үндэслэн Монгол Улсын Засгийн газраас **ТОГТООХ** нь:

1.Зөвшөөрлийн зөвлөлийн нарийн бичгийн даргаар Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга бөгөөд Засгийн газрын Хяналт хэрэгжүүлэх газрын дарга Б.Баасандорж, гишүүнээр Гадаад харилцааны яамны Гадаад худалдаа, эдийн засгийн хамтын ажиллагааны газрын захирал Г.Өлзийсайхан, Эдийн засаг, хөгжлийн яамны Хөгжлийн судалгааны газрын дарга Л.Эрдэнэбаяр, Хууль зүй, дотоод хэргийн яамны Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын ахлах шинжээч А.Энх-Эрдэнэ, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхимын дэргэдэх Хуулийн бодлогын зөвлөлийн дарга Ө.Жамбалсүрэн, Монголын уул уурхайн үндэсний ассоциаци төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал Г.Эрдэнэтуяа, Монголын барилгын үндэсний ассоциаци төрийн бус байгууллагын гүйцэтгэх захирал Л.Хулан, Монголын хүнсчдийн холбоо төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн М.Болод, Баялаг бүтээгчдийг дэмжих холбооны удирдах зөвлөлийн гишүүн Б.Батдэлгэр, Монголын барилгын зураг төсөл зохиогчдын холбооны Бодлогын зөвлөлийн гишүүн Б.Бямбажав нарыг 3 жилийн хугацаагаар томилсугай.

2.Зөвшөөрлийн зөвлөлийн үйл ажиллагаа болон хуралдааныг удирдан зохион байгуулах, хэлэлцэж шийдвэрлэсэн асуудлын гүйцэтгэл, үр дүнг тооцож ажиллахыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргад хариуцуулсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН САЙД,  
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ  
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА

Д.АМАРБАЯСГАЛАН